



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 04 өдөр

Дугаар А/120

Номгон

Мал, амьтны гоц халдварт “Шүлхий”  
өвчинтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 226 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны 187 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2022 оны 04/05 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний халдварыг эрүүл бүс нутагт тархах эрсдэлээс урьдчилан сэргийлж, хамгаалах зорилгоор тус аймгийн Бууцагаан сум дахь Байдрагийн гүүр, Баян-Овоо сум дахь Нарийн голын гүүр, Галуут сум дахь Цагаан туруут голын Ганцын гармын гүүр, Мандалын хийдийн гүүр зэрэг газруудад 2022 оны 03 дугаар сарын 05-ны өдрөөс 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд аймгийн Онцгой комиссын хяналтын нэгдсэн постыг томилгоожуулан ажиллуулсугай.

2. Мал, амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний голомтот бүс нутгаас эрүүл бүс нутгуудад зорчих хөдөлгөөнд хатуу хяналт тавин, халдвар хамгааллын дэглэмийг чанд баримтлуулж, үйл ажиллагааны журмыг хавсралтаар баталсугай.

3. Аймгийн Онцгой комиссын хяналтын нэгдсэн хяналтын пост (1 дүгээр пост /Байдрагийн гүүр/-ыг Цагдаагийн газар, 2 дугаар пост /Ганцын гармын гүүр/-ыг Онцгой байдлын газар, 3 дугаар пост /Мандалын хийдийн гүүр/-ыг Мал эмнэлгийн газар, 4 дүгээр пост /Нарийн голын гүүр/-ыг Хүнс, хөдөө аж ахуйн газар)-нд ажиллах алба хаагчдыг үүрэг гүйцэтгэх нөхцөл боломжоор бүрэн хангаж ажиллахыг хуваарьт байгууллагуудын дарга нарт;

4. Аймгийн Онцгой комиссын хяналтын нэгдсэн хяналтын постыг халдвар хамгааллын хэрэгсэл, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, материалаар бүрэн

601220291


хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга (дэд хурандаа Э.Батбаяр)-д;

5.Голомтот бүс нутгуудтай хил залгаа оршдог сумдууд өөрсдийн нутаг дэвсгэрт шүлхий өвчний халдвар тархахаас хамгаалж, эрсдэл бүхий газруудад хамгаалалтын пост гарган ажиллуулж, үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнийг хариуцлагажуулан ажиллахыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

6.Постын үйл ажиллагаатай холбогдон гарах хоол, хүнс, шатах тослох материалын зардлыг гүйцэтгэлээр нь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Энхжаргал)-т;


7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга, аймгийн Онцгой комиссын удирдлага, зохион байгуулалт хариуцсан орлогч дарга (хурандаа Ж.Алтангэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар  
сарын 07-ний өдрийн А/20 дугаар захирамжийн  
хавсралт



## МАЛ, АМЬТНЫ ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ХАМГААЛАХ НЭГДСЭН ХЯНАЛТЫН ПОСТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдварт өвчин илэрсэн тохиолдолд халдварын голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах, нэгдсэн зохион байгуулалтад оруулах, халдвараас тархахаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2.Хяналтын байранд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүн нь дараах дүрэм, журам, зааврыг мөрдлөг болгон ажиллана. Үүнд:

1.2.1.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль

1.2.2.Засгийн газрын 2018 оны “Хорио цээр хязгаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам” 266 дугаар тогтоол

1.2.3.Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2019 оны “Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх заавар” А/187 дугаар тушаал

1.2.4.Монгол Улсын Хүнс, Хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайдын 2010 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Мал эмнэлгийн халдваргүйжүүлэлтийн заавар”;

1.2.5.Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2013 оны А/468 дугаар тушаалаар батлагдсан “Тусгай цэвэрлэгээний бүлгийн ажиллах журам”;

1.2.6.Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны А/344 дүгээр тушаалаар батлагдсан “Мал, амьтны гоц халдварт өвчний үед онцгой байдлын байгууллага болон гамшгаас хамгаалах албадын харилцан ажиллагааг зохион байгуулах заавар”;

1.3.Энэхүү журмыг тус аймгийн нутаг дэвсгэрт мал, амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд хяналтын постод үүрэг гүйцэтгэх байгууллагын нийт бүрэлдэхүүн мөрдлөг болгон ажиллана.

## **Хоёр.Нэр томъёоны тодорхойлолт**

2.1.Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1.“**Ариутгал, халдваргүйжүүлэлт**” гэж мал амьтан халдварт өвчнөөр халдварлах, сэжиг илрэх үед болон өвчний тархалтыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор өвчин үүсгэгч бактер, мөөгөнцөр, шимэгч биет, вирусийг физик, химийн аргаар идэвхгүй болгох, устгах үйл ажиллагааг;

2.1.2.“**Ариутгалын бодис**” гэж өвчин үүсгэгч бактер, мөөгөнцөр, шимэгч биет болон вирусийг идэвхгүй болгох, устгахад ашиглаж буй химийн бодисыг;

2.1.3.“**Гоц халдварт өвчин**” гэж орон нутгийн хил хязгаараас үл хамааран богино хугацаанд тархаж, хүн, мал амьтны эрүүл мэндэд хохирол учруулж, худалдаа эдийн засгийн байдал сөргөөр нөлөөлөх өвчнийг;

2.1.4.“**Халдварт өвчний голомтын бүс**” гэж хүн, мал амьтны гоц халдварт өвчин илэрсэн үед тархалтыг хязгаарлах, хор уршгийг арилгах зорилгоор хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт тогтоон ариутгал, халдваргүйжүүлэлт хийх ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэрийг;

2.1.5.“**Хяналтын байр**” гэж мал амьтны гоц халдварт өвчин илэрсэн бүсэд, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг тогтоож, иргэд, тээврийн хэрэгсэл, мал, амьтны хөдөлгөөнийг хязгаарлах, ариутгал халдваргүйжүүлэлт хийх, улсын хяналтыг хэрэгжүүлэхээр байгуулсан холбогдох мэргэжлийн байгууллагуудын албан хаагч, техник хэрэгслээс бүрдсэн байрыг;

2.1.6.“**Хязгаарлалтын бүс**” гэж хүн, мал амьтны гоц халдварт өвчин илэрсэн үед тархалтыг хязгаарлах зорилгоор хил тогтоохыг;

2.1.7.“**Хорио цээрийн дэглэм**” гэж богино хугацаанд тархаж, үлэмж хохирол учруулдаг өвчин гарсан үед халдварын тархалтыг голомтод нь хязгаарлан тогтоох, хор уршгийг арилгах үйл ажиллагаанд чиглэсэн иж бүрэн арга хэмжээг хэлнэ.

## **Гурав. Удирдлага зохион байгуулалт**

3.1.Мал, амьтны гоц халдварт өвчин гарсан тохиолдолд хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг аймгийн Мал эмнэлгийн газар зохион байгуулалтаар хангана.

3.2.Хяналтын байранд Мал эмнэлгийн байгууллагын алба хаагч ахлан ажиллах бөгөөд холбогдох мэргэжлийн байгууллагуудыг өдөр тутмын цагийн хуваарийн дагуу ажиллуулна.

### **Дөрөв. Хяналтын байранд ажиллах бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

4.1.Хяналтын постоор нэвтрэн өнгөрөх иргэдийн хувцас, биеийн ил хэсэг, багаж, техник, тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн гадна тал, явах эд анги, тэвшинд ариутгал халдваргүйжүүлэлт хийх, халдварт өвчний сэжиг илэрсэн тохиолдолд авсан дээжийг шуурхай тээвэрлэж, холбогдох байгууллагад хүргүүлэх үйл ажиллагааг тухайн аймгийн Мал эмнэлгийн газраас томилогдсон алба хаагч хариуцан зохион байгуулна.

4.2.Хяналтын байранд нэвтрэн өнгөрөх зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжих хөдөлгөөнд аймгийн Цагдаагийн байгууллагаас томилогдсон алба хаагч хяналт тавьж, хэв журмыг сахиулах ажлыг зохион байгуулна.

4.3.Хяналтын байранд ашиглагдаж байгаа бодис, уусмал, мал эмнэлгийн эм тариа, вакцины чанар, хадгалалт, зарцуулалтын байдалд хяналт тавьж, Засаг даргын захирамжийн биелэлт, хорио цээрийн дэглэмийн хэрэгжилт, стандарт, норм, дүрэм, журам, зааврын биелэлтэд хяналт тавьж, хариуцлага хүлээлгэх ажлыг аймгийн Мэргэжлийн хяналтын байгууллага зохион байгуулна.

4.4.Нөхцөл байдлын мэдээ, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай танилцуулгыг холбогдох дээд шатны байгууллагад цаг тухайд нь шуурхай илтгэн дамжуулах, иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжлийн заавар зөвлөгөө өгөх, ариутгал халдваргүйжүүлэлт, хэв журам сахиулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажлыг Мал эмнэлгийн байгууллагаас томилогдсон алба хаагч зохион байгуулна.

#### **Тав. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа**

5.1.Хяналтын байранд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүнд хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг Онцгой байдлын байгууллагаас томилогдсон эрх бүхий албан хаагч танилцуулж, баталгаажуулна.

5.2.Аймгийн Онцгой комиссын даргын шийдвэрээр хяналтын байранд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний ажиллах цагийн хуваарийг тогтооно.

5.3.Ариутгал, халдваргүйжүүлэлт хийх ажиллагааны үеийн аюулгүй байдал

5.3.1.Ариутгалын бодис, уусмал найруулах, хадгалах, зөөвөрлөх, халдваргүйжүүлэх үед тусгай, зориулалтын арьс болон амьсгал хамгаалах хувцас, хэрэгслийг тогтмол өмсөж, хэрэглэх;

5.3.2.Халдваргүйжүүлэх ажиллагаа дуусан үед хэрэглэсэн нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл, их хэмжээгээр бохирдсон болон ашиглалтын шаардлага хангахгүй багаж, хэрэгслийг устгах;

5.3.3.Үүрэг гүйцэтгэсэн бие бүрэлдэхүүнд халдварын болон хордлогын шинж тэмдэг илэрсэн тохиолдолд нийслэл, дүүргийн эрүүл мэндийн байгууллагад хандаж, шуурхай арга хэмжээг авах;

5.3.4.Хяналтын байрны ахлагч үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүний байрны галлагаа, цахилгаан техникийн бэлэн байдал, аюулгүй ажиллагааг хариуцан ажиллана.

5.4.Ажиллагааны явцад хордлогын шинж илэрвэл салхинд гарч, цэвэр агаараар амьсгалж амаа цэвэр усаар зайлна.

5.5.Ариутгалын бодис нүдэнд орсон, арьс, салст бүрхэвчид хүрсэн тохиолдолд цэвэр усаар сайтар угаана.

5.6.Хорио цээрийн дэглэм цуцалсан өдөр хяналтын байранд үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүн хувцас биеийн ил хэсэг, амны хөндий, багаж техник, тээврийн хэрэгслийн зорчих хэсгийн гадна тал явах эд анги тэвшинд халдваргүйжүүлэлт хийнэ.

#### **Зургаа. Хориглох зүйл**

6.1.Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцаж, гарын үсэг зурж баталгаажуулаагүй алба хаагчийг “Хяналтын пост”-д үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

6.2.Тусгай зориулалтын хамгаалах хувцас хэрэгсэл, багаж хэрэгслээр хангагдаагүй тохиолдолд үүрэг гүйцэтгэхийг хориглоно.

#### **Долоо. Томилолт, урамшуулал**

7.1.Хяналтын байранд үүрэг гүйцэтгэсэн бүрэлдэхүүний томиллолт, урамшууллын зардлыг аймгийн Онцгой комисс хариуцна.

#### **Найм. Хяналт, хариуцлага**

8.1.Энэхүү журмын хэрэгжилтэд аймгийн Онцгой комиссын нарийн бичгийн дарга хяналт тавьж ажиллана.

8.2.Дээрх журмыг зөрсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.